



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/57

Алтрага

**Дуудлага худалдааны тов
зарлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоол, Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 208 тоот тушаал, Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн ээлжит XIV хуралдааны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар эзэмших эрх олгох дуудлага худалдааг явуулах нэгж талбарын газрын хэмжээ, байршил, зориулалт, анхны үнэ, дэнчингийн хэмжээг хавсралтаар баталж, дуудлага худалдааг 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 09,00 цагаас 15,00 цаг хүртэл цахим хэлбэрээр (www.mle.mn) буюу газрын цахим биржээр зохион байгуулсугай.

2.Газар эзэмшүүлэх дуудлага худалдаа явуулах бэлтгэл ажлыг хангаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу цахимаар зохион байгуулж ажиллахыг Газрын даамал (Д.Батсайхан)-д даалгасугай.

3.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Баттулга)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ОДСЭР

Document-Zahiramg

6729010130